

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ӨРГӨН МЭДҮҮЛЭХ, ХУУЛЬ ТОГ-  
ТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХОЛБОГДОХ  
БУСАД ТӨСЛҮҮДИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААР  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН  
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 4 дүгээр  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн Х.Тэмүүжин**

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг нэгдсэн хуралдаанаар 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд 2015 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулиудын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хуулийн нэрийг Хууль тогтоомжийн тухай хууль гэж өөрчлөх, Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг төрийн бодлого судалгаанд үндэслэсэн байх шаардлагын үүднээс хууль тогтоомжийн төсөлд холбогдох мэргэжлийн судалгааны байгууллагын саналыг авсан байх; нэмэлт, өөрчлөлт оруулах болон шинэчлэн найруулах хууль тогтоомжийн төслийг боловсруулахдаа хүчин төгөлдөр үйлчилж буй зохицуулалтын хэрэгжилт, олон улсын эрх зүйд хэрхэн нийцэж байгаад үнэлгээ, дүгнэлт хийсэн байх; Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг “Үндсэн чиглэлийг Улсын Их Хурал хэлэлцэн батална” гэж өөрчлөх, Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт хэрэв хэлэлцүүлгийн үед өргөн мэдүүлсэн төслийн үзэл баримтлал илтэд зөрчигдсэн, төслийн талаар гарсан зарчмын зөрүүтэй санал нь нийт зүйл, заалтын 30-аас дээш хувийг хөндсөн бол төслийг хууль санаачлагчид нь буцаах зэрэг санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тус тус дэмжсэн болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Су.Батболд, Л.Цог нараас төслийн “Хууль тогтоомжийн эмхэтгэлд” гэснийг “Төрийн мэдээлэл эмхэтгэл” гэж өөрчлөх санал гарсныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно. Хэлэлцүүлгийн үед Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин “Хууль тогтоомжийн эмхэтгэл”-д зөвхөн Улсын Их Хурлаас гарсан шийдвэрийг хэвлэн нийтэлдэг байхаар, үүнтэй уялдуулан Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, хуулийн талаарх Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар, яам агентлагаас гаргасан эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг тухайн байгууллага чиг үүргийнхээ хүрээнд өөрөө хэвлэн нийтэлдэг байх зохицуулалтыг нэмж тусгах талаар анхаарах,

Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт төслийн хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шат /7 дугаар зүйл/, хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэр /39 дүгээр зүйл/ болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зохицуулалтууд зөрчилгүй, уялдсан байхад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, С.Баярцогт нараас төслийн 5 дугаар зүйлийн 5.2-т Байнгын хороо хууль санаачлагч байхаар заасан нь Үндсэн хуулийн зөрчил бий болгож болзошгүй тул цаашид хэлэлцүүлгийн шатанд энэ асуудлыг анхаарах шаардлагатай гэсэн саналуудыг гаргасан болно.


Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төсөл, дагалдах бусад хуулийн төсөлтэй холбогдуулан гарсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Байнгын хороо хэлэлцэн санал хураалт явуулж, Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд хэлэлцүүлэхээр Та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гарсан санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



**А.БАКЕЙ**